**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 02 өдөр Дугаар А/738 Номгон

"Идэвхтэй хөдөлгөөн-Эрч хүч" сэдэвт бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах аяныг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, "Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 2.6.35 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Идэвхтэй хөдөлгөөн – Эрч хүч" аяны хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагын алба хаагчид, багийн иргэд, ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдыг хамруулан бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг зохион байгуулсугай.

2. Аяны удирдамжийг 1 дүгээр, зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус батласугай.

3.Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 2.000.000 (хоёр сая) төгрөгийг Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

D:\2021\Zakhiramj-2021 on\Zakhiramj-2021 on.docx 00121 0723

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар
сарын 02-ны өдрийн А/738 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ "ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН – ЭРЧ ХҮЧ" БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ ЧИЙРЭГЖИЛТИЙН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛ АВАХ АЯНЫ УДИРДАМЖ

**Нэг. Үндэслэл**

Манай Улсын 15-69 насны хүн амын 21.9% нь хөдөлгөөний хомсдолтой, суугаа идэвхгүй байдалд хоногт дунджаар 3.4 цагийг зарцуулдаг, 52.4% нь ажлын байрандаа, 48.2% нь амралт чөлөөт цагаараа эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй, 49.4% нь илүүдэл жин ба таргалалттай байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт хүн амын насны бүлэг ахих тутам нэмэгдэх хандлагатай, бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ эрэгтэйчүүдэд 87.3см, эмэгтэйчүүдэд 85,7см байна. Бүсэлхийн тойргийн эрсдэлийн үнэлгээгээр нийт хүн амын 53%, эрэгтэйчүүдийн 41.9%, эмэгтэйчүүдийн 64.2% нь төвийн таргалалттай, хот суурин газрын хүн амд төвийн таргалалт хөдөө орон нутгийнхаас их бөгөөд нийт хүн амын 25.9% нь биед агуулагдах өөхөн эдийн хэмжээ маш их байна.

Иймээс хүн амыг бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн тҮвшин тогтоох сорил судалгаанд хамруулж, дасгал хөдөлгөөнийг нийтийн үйл хэрэг болгон, сурталчлан таниулах, хөдөлгөөнөөр хичээллэх идэвхийг нэмэгдүүлэн, иргэдийн дархлааг дэмжих нь нэн тэргүүний асуудал болоод байна.

**Хоёр.Зорилго**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, Биеийн тамир спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 2 дугаар хуралдааны 2/6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 3.3, "Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.2.2. дахь заалтыг хэрэгжүүлэх

**Гурав. Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах аяны чиглэл**

1.Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын аян зохион байгуулах

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар
сарын 02-ны өдрийн А/738 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

# "ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН –ЭРЧ ХҮЧ" БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ ЧИЙРЭГЖИЛТИЙН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛ АВАХ АЯНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Зарцуулах зүйл | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сорилын хэрэглэгдэхүүн /хөлийн хүч, уян хатан/ | ш | 2 | 85.000 | 170.000 |
| 2 | Цахилгаан Өндөр, жин хэмжигч | ш | 1 | 1.500.000 | 1.500.000 |
| 3 | Банар | ш | 1 | 5х6 11.000 | 330.000 |
| | Нийт дүн | 2.000.000 төгрөг | | | |

________oOo________

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит VI
хуралдааны 6/24 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
2022 ОНЫ ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ,
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/Мянган төгрөгөөр/

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Хэрэгжих | | Төсөвт өртөг | 2022 онд санхүүжих дүн |
|---|---|---|---|---|---|
| | | Эхлэх | Дуусах | | |
| 1 | Есөн-Эрдэнэ захын баруун талаас Хонгор хотхон хүртэлх зам дагуу явган хүний зам хийх | 2021 | 2022 | 514,624.7 | 105,000.0 |
| 2 | Аймгийн төв доторх хатуу хучилттай авто замын нөхөөсний ажлын үлдэгдэл санхүүжилт | 2022 | 2022 | 41,065.0 | 41,065.0 |
| 3 | Аймгийн төв доторх асфальтан хучилттай авто замын хэвтээ тэмдэглэгээний засвар, шинэчлэлт хийх ажлын үлдэгдэл (25000у/м замд) | 2022 | 2022 | 50,000.0 | 50,000.0 |
| 4 | Арван мянгатын хатуу хучилттай 1.2 км зам дагуу явган хүний зам барих, босоо бордюр хийх | 2022 | 2022 | 165,922.0 | 165,922.0 |
| 5 | Аймгийн төв доторх эвдэрсэн 1000м2 талбайд замын нөхөөс хийх | 2022 | 2022 | 50,000.0 | 50,000.0 |
| 6 | Автозамын тухай хуулийн 24.5 дах заалтын дагуу хяналтын зардал | 2022 | 2022 | 15,000.0 | 15,000.0 |
| 7 | Аймгийн төв доторх уулзвар гарцуудыг засварлах | 2022 | 2022 | 140,000.0 | 140,000.0 |
| 8 | Аюулгүйн тойргоос Нэгдсэн эмнэлгийн баруун хойд уулзвар хүртэл 900 метрт хатуу хучилттай авто замыг шинэчлэх | 2022 | 2023 | 501,155.0 | 396,155.0 |
| 9 | Онцгой байдлын газрын уулзвараас Хүнс, хөдөө аж ахуйн газрын урд уулзвар хүртэлх 750 метр замд хатуу хучилттай авто зам хийх | 2022 | 2022 | 451,858.0 | 451,858.0 |
| 10 | Эрдэнэмандал сургуулийн сургууль орчмын бүсийг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах | 2022 | 2022 | 30,000.0 | 30,000.0 |
| 11 | Шаргалжуут тосгоны замын засвар | 2022 | 2022 | 5,000.0 | 5,000.0 |
| | **НИЙТ ЗАРДЛЫН ДҮН** | | | **1,964,624.7** | **1,450,000.0** |
| 1 | Торгуулийн орлого | 2022 | 2022 | | 600,000.0 |
| 2 | Авто зам ашиглалтын хураамж | 2022 | 2022 | | 570,000.0 |
| 3 | Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 2022 | 2022 | | 280,000.0 |
| | **САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | | - | **1,450,000.0** |

oOo

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1.14 | Баянбулаг сумын спорт цогцолбор, цэцэрлэгт хүрээлэнгийн ажил /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/ | 2021 | 2022 | 246,000.0 | 98,265.6 |
| 1.15 | Төв цэнгэлдэх хүрээлэнгийн тохижилт, зүлэгжүүлэлт /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/ | 2021 | 2022 | 134,108.9 | 34,108.9 |
| 1.16 | Баянхонгор аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/ | 2021 | 2022 | 193,391.0 | 154,712.8 |
| **2. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт** | | | | **3,274,904.0** | **2,528,591.0** |
| 2.1 | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, уст цэгийн хайгуул хийх | 2022 | 2022 | 150,000.0 | 150,000.0 |
| 2.2 | Шинэ хогийн цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн байгуулах | 2022 | 2022 | 200,000.0 | 200,000.0 |
| 2.3 | Зорилтот өрхийг чип /CHIP/ багцаар хангах /оролцоо/ | 2022 | 2022 | 150,000.0 | 150,000.0 |
| 2.4 | Баянхонгор сумын Номгон 1-р багийн 514 дүгээр байрыг их засварт оруулах | 2022 | 2022 | 350,000.0 | 200,000.0 |
| 2.5 | Гурван бүсийн цогцолбор цэцэрлэгт хүрээлэнгийн их засварын ажлыг хийх | 2022 | 2022 | 218,472.0 | 90,000.0 |
| 2.6 | Аймгийн ашиглалтын шаардлага хангахааргүй болсон хуучин барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөх | 2022 | 2022 | 540,000.0 | 540,000.0 |
| 2.7 | Баянхонгор сумын 2, 3, 7 багийн гудамжнуудын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх | 2022 | 2022 | 150,000.0 | 150,000.0 |
| 2.8 | Шаардлагатай газруудад цахилгаан шугам, дэд станцын өргөтгөл хийх | 2022 | 2022 | 200,363.0 | 200,363.0 |
| 2.9 | Баянхонгор сумын Оточномгон өрхийн эмнэлэг барих | 2022 | 2022 | 829,791.0 | 400,000.0 |
| 2.10 | ДНТ зургийн компани өглөг | 2021 | 2022 | 118,050.0 | 80,000.0 |
| 2.11 | Хүрээмарал сумын Сувраа уулын орой дахь Жи-Мобайлын сүлжээг дахин дамжуулах станцын өргөтгөл шинэчлэл | 2022 | 2022 | 23,000.0 | 23,000.0 |
| 2.12 | Малын үзлэг хийх, цөм сүрэг бий болгох | 2022 | 2022 | 60,000.0 | 60,000.0 |
| 2.13 | Наадмын зардал | 2022 | 2022 | 20,000.0 | 20,000.0 |
| 2.14 | Шаардлагатай зураг төсвийг хийлгэх | 2022 | 2022 | 265,228.0 | 265,228.0 |
| **НИЙТ ДҮН** | | | | **8,801,132.1** | **4,542,163.9** |
| | ОНХС санхүүжилт (саналтай байх) | | | | 4,192,163.9 |
| | Суурь орлого | | | | 100,000.0 |
| | Зураг төсвийн орлого | | | | 250,000.0 |
| **САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | | | | **4,542,163.9** |

oOo